



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/127

Мандалговь

Аймгийн хурдан морины бүсийн уралдааны  
2022 оны хуваарийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Нарны хүлэг” морин спорт уяачдын холбооны болон сумдын Засаг дарга нарын саналыг үндэслэн 2022 онд зохион байгуулах аймгийн хурдан морины бүсийн уралдааны хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хурдан морины уралдааныг холбогдох хууль тогтоомж болон “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага” MNS6264:2018 стандартыг бүрэн хангаж, зохион байгуулалтын өндөр төвшинд явуулахыг сумдын Засаг дарга, “Нарны хүлэг” морин спорт уяачдын холбоо (Л.Алтанхуяг)-нд тус тус даалгасугай.

3. Хурдан морины уралдааны явцад морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, байнгын хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ц.Ганзориг), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



4822100307

Аймгийн Засаг даргын 2022 оны  
03 дугаар сарын 25 өдрийн... А/127  
дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ХУРДАН МОРИНЫ БҮСИЙН УРАЛДААНЫ  
2022 ОНЫ ХУВААРЬ

№	Хурдан морины уралдааны нэр	Уралдаан зохион байгуулах газар	Уралдах нас	Хугацаа
1	"Мандалын хурд-2022" аймгийн төвийн бүсийн хурдан морины уралдаан	Өлзийт сум	1. Их нас 2. Соёолон 3. Хязаалан	2022.05.01
2	Дэлгэрхангай уулын тахилга аймгийн баруун бүсийн хурдан морины уралдаан	Дэлгэрхангай сум	1. Их нас 2. Соёолон 3. Даага	2022.05.09
3	Угтаал уулын тахилга аймгийн зүүн бүсийн хурдан морины уралдаан	Говь-Угтаал сум	1. Азарга 2. Их нас 3. Соёолон	2022.06.08
4	EFES группын нэрэмжит аймгийн бүсийн уралдаан	Хулд сум	1. Шүдлэн 2. Даага	2022.05.07
5	Аймгийн зүүн бүсийн хурдан морины уралдаан	Өндөршил сум	1. Азарга 2. Их нас 3. Соёолон 4. Сонгомол дунд нас	2022.07.15-16
6	Аймгийн баруун бүсийн хурдан морины уралдаан	Луус сум	1. Хязаалан 2. Шүдлэн 3. Даага 4. Сонгомол бага нас	2022.07.09-10
7	Баян Уулын тахилга аймгийн зүүн бүсийн хурдан морины уралдаан	Цагаандэлгэр сум	1. Азарга 2. Их нас 3. Соёолон	2022.07.09
8	Аймгийн баруун бүсийн хурдан морины уралдаан	Эрдэнэдалай сум	1. 6 нас 2. Сонгомол дээд болон дунд нас	2022.07.15-16